



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ШААРДЛАГА

2022 оны 04 дугаар сарын 18

№ 04/13

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГҮЙЦЭТГЭХ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ТАНАА

Иргэн "...шүүхийн шийдвэрийн цахим санд миний хувийн мэдээлэл болох регистрийн дугаар, гэрийн хаяг, овог нэрийг арилгахгүйгээр байршуулсан нь хувь хүний нууцаа хамгаалуулах эрхийг зөрчиж байна" гэх гомдлыг Комисст гаргажээ.

Гомдлын дагуу баримтыг хянаж, холбогдох хууль тогтоомжид дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна.

Нэг. Үйл баримт

1. Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2010 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн хурлаар дэмжиж "Шүүх эрх мэдлийн хүрээнд шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байлгах, шүүгч, эрдэмтэн, багш, судлаач, шинжээч, хуульчдад судалгааны ажил хийх, оюутан сурагчдад гарын авлага болгох, хуулийг нэг мөр, зөв хэрэглэх, жишиг тогтоох зорилгоор бүх шатны шүүхийн шийдвэрийг цахим хуудсанд байршуулж, "Шүүхийн шийдвэрийн цахим сан"-г ажиллуулж эхэлсэн байна. 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн new.shuukh.mn цахим санд нийт 112,909 хэргийн 163,041 шийдвэр, old.shuukh.mn цахим санд 79,388 хэргийн 109,643 шийдвэрийг тус тус байршуулжээ.

2. дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 181/ШШ2017/00161 дугаартай шийдвэрээр иргэн Т-н нэхэмжлэлтэй иргэн Г.Мягмарсүрэнд холбогдох иргэний хэргийг шийдвэрлэсэн байх бөгөөд уг шүүхийн шийдвэрийг old.shuukh.mn, new.shuukh.mn нэртэй шүүхийн цахим санд байршуулахдаа иргэний хэргийн оролцогчдын ургийн овог, эцэг, эхийн нэр, нэр, регистрийн дугаар, гэрийн болон оршин суугаа хаяг, байгууллагуудын бүртгэлийн дугаар зэргийг нийтэд нээлттэй тавьсан байна.

3. Шүүхийн цахим сан old.shuukh.mn, new.shuukh.mn сайтуудад байршуулсан зарим шийдвэрүүдийг санамсаргүй түүвэрлэн хянаж үзэхэд хэргийн оролцогчдын нэр, регистрийн дугаар, байгууллагуудын бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаягийг бүтнээр оруулсан нь тодорхой харагдаж байна.

Хоёр. Эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэгт "...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 17 дугаар зүйлд "Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно", Хувь хүний нууцын тухай хуулийн 6 дугаар зүйлд "Хувь хүний нууц" гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ" гэж тус тус зааж, халдашгүй чөлөөтэй байх, хувийн орон зай, хувийн нууцаа хамгаалуулах хүний эрхийг баталгаажуулсан.

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сард баталсан, 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс үйлчлэх Хүний хувийн мэдээлэл, хамгаалах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглахад хүний эрх, эрх чөлөөг зөрчихгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмуудыг тогтоожээ. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл нь хязгаарлалттай мэдээлэл бөгөөд хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр танилцах, ашиглах, гуравдагч этгээдэд дамжуулахаар зохицуулсан. Хувь хүний мэдээлэл хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь хэсэгт "хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг" хүний эмзэг мэдээлэл, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх хэсэгт хүний эмзэг мэдээлэл болон хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа газрын хаяг, байршил, иргэний бүртгэлийн дугаар, хөрөнгө, боловсрол, гишүүнчлэл, цахим тодорхойлогч, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг хүний хувийн мэдээлэлд тооцохоор тус тус заасан байна.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2012 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам батлах тухай" тушаалын 1 дүгээр хавсралтын 3.8 дахь хэсэгт "хувь хүний захидал харилцаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, гэр бүлийн нууц байж болзошгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээ, хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болзошгүй гэж үзсэн шийдвэрийг шүүгч, шүүх бүрэлдэхүүнд танилцуулж нууц гэж үзвэл файл хэлбэрээр тусгай хавтаст хийж өгнө", мөн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А/44 дугаар тушаалаар "Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам батлах тухай" уг журмыг шинэчилж, 1 дүгээр хавсралтын 3.6 дахь хэсэгт Цахим санд шүүхийн шийдвэр байршуулахдаа

шийдвэрт дурдсан иргэн, хуулийн этгээдийн регистр, бүртгэлийн дугаар болон хаягийг устгаж, тэдгээрийн нэрийн зөвхөн эхний үсгийг үлдээхээр зохицуулсан байна.

Иргэн болон бусад иргэд, байгууллагуудад холбогдох мэдээллийг шүүхийн цахим санд нээлттэй байршуулсан нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, уг харилцааг тусгайлан зохицуулсан журмыг зөрчиж байна.

Гурав. Комиссын гишүүний шаардлага

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөний зөрчлийг таслан зогсоох, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авахыг шаардаж байна. Үүнд:


1. Шүүхийн цахим сан / old.shuukh.mn, new.shuukh.mn /-д байршсан Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 181/ШШ2017/00161 дугаартай шийдвэрт дурдсан иргэдийн ургийн овог, эцэг /эх/-ийн болон хэргийн оролцогч нарын нэр, регистрийн дугаар, гэрийн хаягийг устгаж, тэдгээрийн нэрийн эхний үсгийг оруулж журамд нийцүүлэх;

2. Шүүхийн шийдвэрийн цахим сан /old.shuukh.mn, new.shuukh.mn/-д байршуулсан бусад иргэд, байгууллагын мэдээллийг Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээ, журамд нийцүүлэн арга хэмжээг үе шаттай авч, хувь хүн, байгууллагын мэдээллийг хамгаалах.

Комиссын гишүүний Шаардлагын хэрэгжилтийг хангаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, биелэлтийн талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу 30 хоногийн дотор хариу ирүүлнэ үү. Энэ шаардлагын 3 дахь хэсгийн 3 (2)-т заасан ажлыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх боломжгүй тохиолдолд энэ талаар төлөвлөгөө, шийдвэр гаргаж, хуулбарыг Комисст ирүүлж болно.

Танай үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Европын Хүний эрхийн шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэхэд баримтлах заавар /Англи хэлээр/-ыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 97 хуудастай.

ГИШҮҮН  Г.НАРАНТУЯА